



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/07

Булган сум

Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал,
ажлын байрыг дэмжих жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймагт 2023 оныг “Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг жил” болгон зарласугай.

2. “Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, жилийн ажлын удирдамжийг 2 дугаар, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил”-ийн ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

4. “Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил”-ийн ажлыг сум, орон нутагтаа зохион байгуулах ажлын хэсэг томилж, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, иргэд, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагыг татан оролцуулж, салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлэн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, зээл, зээлийн батлан даалтад хамруулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах, Байгаль хамгаалах сангийн “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих” төсөл болон хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай), Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Засаг Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010141

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дугаар сарын 10-ны өдрийн А.А.7 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:
Гишүүд:

- Д.Жаргалсайхан /Аймгийн Засаг даргын орлогч/
Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)
Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
албаны дарга)
Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
С.Алтанзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн)
Ц.Бүрэнтуяа (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
дарга)
Г.Алдармөнх (Соёл урлагийн газрын дарга)
Сумын Засаг дарга нар
Д.Оюунгэрэл (Худалдаа аж үйлдвэрийн танхимын
дарга)
Д.Мэндсайхан (Ажил олгогч эздийн холбооны тэргүүн)
Ч.Сарантуяа (Тогооч нарын холбооны тэргүүн)
О.Амаржаргал (Булган аймгийн Аялал жуулчлалын
холбооны тэргүүн)
Б.Анхбаяр ("Хотол Булган хамтын ажиллагаа" төрийн
бус байгууллагын тэргүүн)
Г.Ганзориг (Барилагчдын холбооны тэргүүн)
Д.Эрдэнэчимэг (Үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний
нэгдсэн холбооны тэргүүн)
Т.Жаргалант (Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны
тэргүүн)
Нарийн бичгийн дарга: Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
орруулалтын хэлтсийн Үйлдвэрлэл, үйлчилгээний
салбарын бодлого зохицуулалт хариусан мэргэжилтэн)
А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга)

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дугаар сарын 10-ны өдрийн А/01 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**“ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЖЛЫН БАЙРЫГ
ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Монгол Улсын болон аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрт Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, Засгийн газраас 2023 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, стандарт хангалтыг дээшлүүлэхэд оршино.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Булган аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх бодлого (2014-2020)”, аймгийн Засаг даргын 2021 оны А/223 дугаар Захирамжаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө (2021-2022)”, аймгийн Засаг даргын 2022 оны А/129 дүгээр Захирамжаар “Булган аймагт 2022-2025 онд хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрийн Тэргүүлэх салбарын жагсаалт”-ыг баталж, “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-ын 2019 оны XII/02 дугаар тогтоолоор, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 39 дүгээр тогтоолоор тус тус батлуулж, 2022 оныг аймгийн “Аялал жуулчлалын жил” болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлж ирсэн байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг өрнүүлж, монгол улс 5 жилийн хугацаанд хүнсний 19 гол нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангахаас гадна экспортлогч орон болох зорилтыг салбарын хэмжээнд өрнүүлээд байна.

Манай аймгийн хувьд дотоодын худалдаа эдийн засгаа дэмжсэн зах зээлийн тогтолцоогүй, их хотын дэргэд гадагшаа чиглэсэн худалдан авалтын урсгалтай байгаа нь орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг бууруулах, судалгаанд суурилсан аймгийн онцлогт тохирсон хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор МҮХАҮТ, НҮБ-ын олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Булган аймгийн нийгэм эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар”-ыг боловсруулуулж, хүлээж аваад байна.

(Булган аймгийн нийгэм эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар”-ын судалгааг үзэх)

Тус судалгаагаар цар тахлын нөлөө буурсан ч нийт ажил эрхлэлт ковидын өмнөх төвшинд 6-7 жилийн дараа буюу 2028 онд хүрэхээр байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлого баримтлахгүй бол цар тахлын нөлөөлөл урт хугацаанд үргэлжилж, үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт 5 хувиар буурах төлөв гарсан байна.

Аймгийн ДНБ 2021 оны гүйцэтгэлээр 485.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 21.6 хувиар өсч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээглэхүүн 7.8 сая төгрөгт хүрч, 21.0 хувиар тус тус өссөн байна. Хөдөө аж ахуйн салбар 62.8 хувь, үйлдвэрлэлийн салбар 14.6 хувь, үйлчилгээний салбар 22.4 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн ДНБ-ий 50 %-аас дээш Хөдөө аж ахуйн салбар дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэлээс шууд хамаарч байна. Нийт үйлдвэрлэлийн тоо хэмжээ нэмэгдэж байгаа ч нэг хүнд ноогдох ДНБ төдийлөн нэмэгдэхгүй байгаа учир үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2021 оны байдлаар боловсруулах салбарт 673 хүн хөдөлмөр эрхэлж, нийт 66.4 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулж байна. Эдийн засгийн эргэлтийн хурдыг хамгийн сайн нэмэгдүүлэх үйлчилгээний салбарын үйлдвэрлэл бусад салбарт нөлөөлөх маш чухал нүүр царай болоод байна.

Худалдааны салбарт 347 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарт 41 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, нийт 107.0 тэрбум төгрөг үйлдвэрлэж байгаа бөгөөд 2040 он гэхэд 160.0 тэрбум төгрөг болж даруй 60 % өсөх төлөвтэй байна.

Аймгийн нутаг дэвсгэрээр зорчих их урсгалд худалдаа үйлчилгээний салбарын нийт үйлдвэрлэл өсөн нэмэгдэх асар их боломж байгаа бөгөөд тав тухтай зочид буудлын хэрэгцээ шаардлага маш их байна. Иймд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг оновчтой байршуулахад хөгжлийн төлөвлөлттэй уялдсан төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай байна.

Цаашид Байгаль түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, аялал жуулчлалыг орон нутгийнхаа эдийн засгийн үр өгөөжтэй салбар болгох, аялал жуулчлалын аж ахуйн нэгж байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтоо үргэлжлүүлж, тогтвортой хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн тул “2023 оныг Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил” болгон зарлаж байна.

Хоёр. Зорилго

Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын тогтвортой өсөлтийг дэмжиж, орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах, аялал жуулчлалын жилд хүрсэн үр дүнгээ тогтворжуулж, ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЖИШИГ АЙМАГ болох зорилтоо хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өрнүүлж, хөрөнгө оруулалтыг татаж, оновчтой байршуулна.

Гурав. Хамрах хүрээ

Аймгийн хэмжээнд бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж болон Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдана.

Дөрөв. Зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр

- Хот хөдөөгийн сэргэлтийн бодлоготой уялдуудан “Хөрөнгө оруулагчдын чуулган” зохион байгуулах,

- Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах давтан сургах
- Бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан Бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх
- Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн санал хүсэлтийг сонсох
- Монгол улсын хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэлийг амжилттай хэрэгжүүлж байгаа аймаг, орон нутаг, аж ахуйн нэгжээс туршлага судлах, түгээн дэлгэрүүлж, кластераар хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх ажлыг зохион байгуулах
- Хамрах хүрээний байгууллагууд жилийн ажлын хүрээнд гадаад дотоод орчны тохижилт хийж, үйлчилгээний таатай орчинг бүрдүүлэх
- Байгууллагын болон үйлчилгээний соёлыг төлөвшүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарах
- Булган аймгийн Брэнд бүтээгдэхүүний сав баглаа боодол хаяг шошгийн уралдаан зарлаж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх
- Үйлчилгээний байгууллагын дэлгэрэнгүй танилцуулгын апп бий болгож /платформ/ Булган аймгийн бүс нутагт орж ирэхэд мэдээлэл авдаг болгох ажлыг эхлүүлэх

4.2.Мэдээ, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиглэлээр

- Бизнесийн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг сурталчилах цуврал нэвтрүүлэг хийх
- Монголд зочлох жил, Үйлдвэрлэл үйлчилгээ аялал жуулчлал, ажлын байрыг хөгжүүлэх жилийн тухай олон нийтийн сүлжээгээр сурталчлах, таниулах
- Аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ, виртуал аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Булган аймгийн тухай контент хөгжүүлэлтийг дэмжиж, кино нэвтрүүлэг хийж, олон нийтэд хүргэх

4.3.Бүс нутгийн менежмент, засаглал, хамтын удирдлагыг төлөвшүүлэх чиглэлээр

- Аялал жуулчлалын гол бүс нутгуудад "Зочид буудлын сүлжээ", "Айлчин гэр нөхөрлөл" байгуулах санал санаачлалыг дэмжих
- Аялал жуулчлалын чиглэлийн шинэ санал, санаачилга нэвтрүүлж байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх

4.4. Эвент арга хэмжээг зохион байгуулах, брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах чиглэлээр

- ITM-2023, Airag day үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
- Эвент арга хэмжээнүүдийг шат дараатайгаар зохион байгуулах
- Төвийн бүсийн аймгуудын Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түншлэл үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
- Улсын болон ОУ-ын үзэсгэлэн худалдаанд орон нутгийн бизнес эрхлэгчдийг зохион байгуулан оролцуулах

4.5.Байгаль орчныг хамгаалах, орчныг бохирдлыг багасгах чиглэлээр

- Аялал жуулчлал дагасан хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх
- Эко ариун цэврийн байгууламжийг байгуулах

- Рашаан, уст цэгийг хашиж хамгаалах, ухуулга сурталчилгааны самбар байрлуулах

4.6.Тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлээр

- “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэл үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх
- Хутаг-Өндөр сумын Урантогоо уулын орчмыг тохижуулах зураг төсөв боловсруулах
- Түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах
- Аялагч, амрагчдын отоглох цэгийн тохижилтыг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэл үйлчилгээний газрыг холбогдох стандартад нийцүүлж, гадна дотор орчныг тохижуулах

4.7.Үйлчилгээний чанар стандартыг сайжруулах чиглэлээр

- Үйлдвэрлэл үйлчилгээний технологийн төрөлжсөн сургалт зохион байгуулах
- Үйлчилгээний байгууллагуудын стандартыг мөрдүүлэх
- Ажил олгогчдыг ажилтан, албан хаагчдын эрэлтэд нийцсэн ажлын байрны орчин, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглүүлэх

4.8.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр

- Аж ахуй нэгжүүд өөрийн эзэмшлийн талбайд жилд 2-оос доошгүй удаа мод тарих
- Мод тарих талбайгүй байгууллагуудад мод тарих нэгдсэн газрыг зааж өгөх/ойн сан, тал хээр/
- Ногоон ирээдүй, ногоон орчинг бүрдүүлж тав тухтай амрагчдыг амраах

Тав. Хэрэгжих хугацаа, удирдлага зохион байгуулалт, санхүүжилт

5.1 Хэрэгжүүлэх хугацаа: Жилийн ажлыг аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд зохион байгуулна.

5.2 Гүйцэтгэлийн зохион байгуулалт, хяналт: Жилийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, эдийн засаг, нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Сумын Засаг дарга нар “Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил”-ийн ажлын хэрэгжилтийг хангах аялал жуулчлалын зөвлөл байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор, хагас жилийн тайлан, мэдээг 2022 оны 07 дугаар сарын 01, жилийн эцсийн тайлан, мэдээг 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар Жилийн ажлын тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тайлагнана.

5.3 Санхүүжилт:

Жилийн ажлын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улс, орон нутгийн төсөв
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Хоршоо хөгжүүлэх сан

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан
- Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, ТББ-ын санаачлагаар бүрдсэн тусламж хандивын хөрөнгө
- Байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө

2020 онд аймгийн нийт үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ аж үйлдвэр 18 хувь, хөдөө аж ахуй 56 хувь, үйлчилгээ-26 хувь байна.

Нийт үйлдвэрлэл ХАА-н салбараас шууд хамааралтай бөгөөд хамгийн олон хүн ажиллаж байна. Хамгийн өндөр бүтээмжтэй боловсруулах үйлдвэрлэлийн салбарт маш цөөн хүн ажиллаж байна.

Аймгийн Задаг даргын 2023 оны
10-ны өдрийн А/ОГ дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

“ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.01.12

Булган аймаг

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая.төг/	Суурь түвшин 2022 он	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Үндсэн хэрэг-жүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	
1	2	3	4	5	6	7	8	9	
	Зорилго: Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын тогтвортой өсөлтийг дэмжиж, орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулж, бүтээмжийг өсгөх, аялал жуулчлалын жилд хүрсэн үр дүнгээ тогтворжуулж, ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЖИШИГ АЙМАГ болох зорилтоо хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. - Тер, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өрнүүлж, хөрөнгө оруулалтыг татаж, оновчтой байршуулна. - Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг жилийн ажилтай уялдуулан хэрэгжүүлнэ.								
Зорилт 1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр									
1.1	Бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд орон нутгаас шалтгаалсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагын бүх үе шатанд бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээг ил тод нээлттэй, шуурхай зохион байгуулах чиглэлийг бүх хэлтэс агентлагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	-	ЭЗБӨЧСТ-ийн 2022 оны судалгаагаар Булган аймгийн өрсөлдөх чадвар 2021 оноос 11 оноогоор өсөж, 19-рт эрэмбэлэгдсэн.	Төрөөс бизнес үзүүлэх үйлчилгээ ил тод нээлттэй болсон байна.	04 сар	АЗДТГ, ТЗУХ, ХБТХОХ	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	
1.2		Худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд шинэчлэгдэн батлагдсан Зөвшөөрлийн тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Улсын хураамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт мэдээлэл зохион байгуулах	-	Зөвшөөрлийн тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Улсын хураамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт мэдээлэл зохион байгуулах	Оролцогч талуудад хуулийг сурталчилан таниулж, сургалт мэдээллээр ханган төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн зохион байгуулна.	2,3,4 улирал	АЗДТГ, ХБТХОХ	СХХ, ХХААГ, ОБГ, ЦХ, ТХ, БОАЖГ, ГХБХБГ, СЗДТГ	

1.3	Орон нутгийнхаа бизнес эрхлэгчдийн ажлын байранд нь очиж үйл ажиллагаатай танилцаж санал хүсэлтийг нь сонсож, шийдвэрлэхэд анхаарах	ОНТ	Ахуйн үйлчилгээ эрхлэгчид, болон орон нутгийн үйлдвэрлэгчдийн ажлын байртай нь танилцсан	Хүнс, үйлдвэрлэлийн байртай танилцаж, санал хүсэлтийг нь сонсож, бодлого төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх	2,3 улирал	АЗДТГ, ХБТХОХ, СХХ, ХХААГ	СЗДТГ
1.4	Ахуйн үйлчилгээний төв буюу Бизнес инкубатор, технологи дамжуулах төвийн зураг төсвийг гүйцэтгэхээс хүлээж авах	ОНТ-41.5 сая төсөл хөтөлбөр	2022 онд "Аслаан" ХХК-аар Ахуйн үйлчилгээний зураг төсвийг 41.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлж байна.	Ахуйн үйлчилгээний төв буюу Бизнес инкубатор, технологи дамжуулах төвийн зураг төсвийг авч, хүлээн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд анхаарч ажиллана.	1,4 улирал	ГХБХБГ, ХХААГ	ХХААХҮЯ, Булган СЗДТГ, Мэргэжлийн холбоод
1.5	СХХ-ийн дэргэдэх хүнсний хими, нян судлал, таримал ургамал үр хорио цээрийн лабораторид засвар үйлчилгээ хийх	20.0 сая	Хөрөнгө шийдвэрлүүлэх хүсэлт уламжилсан	Хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна.	3-5 сар	АЗДТГ, СХХ	XX
1.6	СХХ-ийн хүнсний хими, нян судлал, таримал ургамал үр хорио цээрийн лабораторид шаардлагатай тоног, төхөөрөмж урвалж бодисоор хангах	УТ 32.9 сая, ОНТ 20.0 сая	Шаардлагатай санхүүжилтийн тооцоо судалгааг ОН хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал өгсөн	Хүнсний хими, нян судлал, таримал ургамал үр хорио цээрийн лаборатори шаардлагатай урвалж бодисоор хангагдаж, шинжилгээ хийсэн байна.	2,3,4 улирал	АЗДТГ, СХХ	XX
1.7	Үйлдвэрлэл үйлчилгээний цэгүүдэд ашиглагдаж байгаа ариун цэврийн байгууламжийн судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	УТ, ОНТ, ХХ	-Аялал жуулчлалын 123 чэгээс 53 цэг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай -Бусад үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн	Стандартад ариун нийцсэн цэврийн байгууламжийн тоо	2,3 улирал	Сумдын ЗДТГ, БОАЖГ, СХХ	XX

				ариун байгууламжийн судалгаа байхгүй	Цэврийн байгууламжийн судалгаа байхгүй	-Суурь үзүүлэлтээс 10- аас доошгүй фunktээр ахиулна			
Зорилт 2. Бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх									
2.1		"Хөрөнгө чуулган" зохион байгуулах, хөрөнгө оруулалт татах, сурталчилах, мэдээлэл солилцох	ОНТ, төсөл хөтөл- бөр, хувийн хэвшил /25.0/	Аймгийн Аялал жуулчлалын зөвлөгөөн, Тариаланчдын зөвлөгөөн, Хүнсний хувьсгалын нээлтийн арга хэмжээг тус тус зохион байгуулсан	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	06 сар	ЭЗХЯ, АЗДТГ, Арилжаа ны банкууд	ХХААГ, ГХБХБГ, БОАЖГ, Төсөл хөтөлбөр, хувийн хэвшил	
	Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлэх, Урамшуулах	"Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан", "Хоршоо хөгжүүлэх сан", "Зээлийн батлан даалтын сан"-ийн журам, төсөлд тавигдах шаардлагуудыг бизнес эрхлэгчдэд сурталчилж, зээлдэгчдийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх сургалт арга зүйгээр хангах	УТ, төсөл хөтөл- бөр	2022 оны байдлаар ЖДҮХС-аас 2 аж ахуйн нэгжийн 147.0 сая төгрөг, "Хоршоо хөгжүүлэх сан"- аас 452 төсөл 3662.2 сая төгрөгийн зээл авсанаас хэвийн ангилалд 178 төслийн 1753.4 тэрбум төгрөгийн зээл, муу зээлийн ангилалд 274 төслийн 1908.6 сая төгрөгийн зээл багтаж байна.	"Хоршоо хөгжүүлэх сан"-ийн хугацаа хэтэрсэн зээлийг жилд 5- аас доошгүй хувь бууруулж, шинээр зээл олгох нөхцөлийг бүрдүүлж, оновчтой хувиарласан байна.	1,2,3,4 улирал	АЗДТГ ХХААГ GIZ- "Эдийн засгийн өсөлт бизнес эрхлэл- тийг дэмжих төсөл"	СЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ, ШШГГ, Хувийн хэвшил, Арилжааны банк	
2.2		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгт иргэдийг хамруулж, ажлын байрыг хадгалах болон шинээр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	УТ, төсөл хөтөл- бөр	2022 онд Хөдөлмөр эрхлэлтийг Дэмжих сангийн 12 зорилтот хөтөлбөрт нийт 867 хүн хамруулж, 1195.2 сая төгрөг зарцуулсан байна.	2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 12 зорилтот хөтөлбөрөөс 1.4 тэрбум төгрөгийн дэмжлэг хэрэгжүүлнэ.	1,2,3,4 улирал	ХХҮГ	СЗДТГ	
2.3		Гарааны бизнесийг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх	ОНТ, төсөл хөтөл- бөр	2022 онд "Айрагтай такс"- төсөлд 10.0 сая төгрөг олгож амжилттай хэрэгжиж байна.	Гарааны Бизнесийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	04 сар, 2,3,4 улирал	ХХҮГ, ХХААГ	АЗДТГ, МСҮТөвүүд Мэргэж-лийн холбоод	
2.4		Булган аймагт шилжин ирсэн иргэдийг бизнес	УТ	Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого батлагдсан.	"Нээлттэй Булган" хөтөлбөрийг	1,2,3,4 улирал	АЗДТГ	СЗДТГ	

	эрхлэлтийг Дэмжсэн Засгийн газрын хөнгөлттэй тусламжид хамруулахад Дэмжлэг үзүүлэх	эрхлэлтийг Дэмжсэн Засгийн газрын хөнгөлттэй тусламжид Дэмжлэг үзүүлэх		Орон нутгийн Брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг органик бүтээгдэхүүнд шилжүүлэхээр 3 ААН-ийн 5 нэрийн бүтээгдэхүүн шилжилтийн гэрээ байгуулан ажиллаж байна	хэрэгжүүлсэн байна.			
3.1	“Нэг сум-Нэг брэнд бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг эрчимжүүлж, шинээр брэнд болох бололцоо бүхий бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийж, баталгаажуулах	ОНТ, төсөл хөтөлбөр, хувийн хэвшил		Бүтээгдэхүүн өрсөлдөх чадвар сайжирч, ногоон баталгаажуулалт, эко шошго олгуулах бэлтгэл ажил хангагдсан байна. Ногоон баталгаажуулалт ба шошгоны ач холбогдлын талаар зан дадлын өөрчлөлт бий болгоно.	Бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжирч, ногоон баталгаажуулалт, эко шошго олгуулах бэлтгэл ажил хангагдсан байна. Ногоон баталгаажуулалт ба шошгоны ач холбогдлын талаар зан дадлын өөрчлөлт бий болгоно.	5, 9 сар	СХХ, ХХААГ,	ХХ, СЗДТГ ЕХ-ны Свич - Эйшиг хөтөлбөр “Эдийн засгийн ногоон шилжилт”, төсөл, GIZ- Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих төсөл
3.2	Жижиг, дунд үйлдвэрлэлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжилтэй ажиллагсдыг чадавхижуулах	Баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хаяг, шошгонд “Гэрчилгээжсэн тэмдэг”-ийг байршуулах арга хэмээг авч ажиллах	ХХ	2021 онд 24 нэрийн бүтээгдэхүүн, 110 үйлчилгээ 2022 онд 34 нэрийн бүтээгдэхүүн, 194 үйлчилгээ баталгаажуулсан	Бүтээгдэхүүн-100, Үйлчилгээ 70	1,2,3,4 улирал	СХХ,	СЗДТГ, Аж ахуйн нэгж, иргэд
3.3	Аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч” шагналын болзолыг сурталчлан таниулж, шаардлага хангасан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийг шагнаж урамшуулах	Аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч” шагналын болзолыг сурталчлан таниулж, шаардлага хангасан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийг шагнаж урамшуулах	ОНТ 3.0	2022 онд 1 үйлдвэрлэгч, 1 үйлчилгээ эрхлэгчийг шагнаж урамшуулсан	Шагналын болзолын шаардлага хангасан бизнесийг шагнаж урамшуулна.	3 улирал	АЗДТГ, СХХ ХХААГ	СЗДТГ, Мэргэжлийн холбоод
3.4	Аймгийн “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн” зохион	“Аялал жуулчлалын зөвлөгөөн” зохион байгуулсан	ОНТ		Зөвлөгөөн зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн санал	3 сар	ХХААГ	СЗДТГ, Мэргэжлийн холбоод

Зорилт 3. Бизнесийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх

3.5	байгуулж, салбарын хууль эрх зүйн мэдээллээр хангах	"2023 оны улсын залуу аварга тогооч шалгаруулах" ур чадварын уралдааныг зохион байгуулах	ОНТ	Улсын уралдааныг орон нутагт зохион байгуулсан туршлага байхгүй	Ур чадварын уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулна.	1 сар	АЗДТГ	СХХ, ХХААГ Тогооч нарын холбоо
3.6	Хоол, хүнсний зөв, зохистой соёлтой хэрэглээний талаарх сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах	"Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлогтой брэнд хоол шалгаруулах, хоол үйлдвэрлэлийн уламжлал ба инновац-сурталт, ур чадварын уралдаан зохион байгуулж, 11 сумын 8 багийн 146 хоол үйлдвэрлэлийн салбарын ажилчид хамрагдсан.	ОНТ		Зочлох үйлчилгээний сургалт зохион байгуулсан байна.	2,3,4 улирал	ХХААГ, СХХ, ЭМГ	СЗДТГ, Тогооч нарын холбоо
3.7	Орон нутгийн онцлогтой идээ ундааг хөгжүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх	Орон нутгийн онцлог нэрийн хоолтой болох саналыг аймгийн Тогооч нарын холбоо гаргасан.	ОНТ, Хувийн хэвшил		Булган аймгийн онцлог нэрийн "Тэргүүн шимт" хоолыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх	1,2,3,4 улирал	Тогооч нарын холбоо, СЗДТГ	АЗДТГ, ХХААГ, СХХ
3.8	Заавал баталгаажуулах үйлчилгээний баталгаажуулалтын төрлийг нэмэгдүүлэх	Заавал баталгаажуулах үйлчилгээний баталгаажуулалтын төрлийг нэмэгдүүлэх	УТ, ХХ	-Баталгаажуулсан үйлчилгээний төрөл -Баталгаажсан үйлчилгээний нийт цэгт эзлэх хувь	- 9 - 56 - 11 - 70	1,2,3,4 улирал	СХХ	СЗДТГ, аж ахуйн нэгж, иргэд
3.9	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд менежмент, стратеги, мэдээллийн технологи, маркетинг, хүний нөөц, компанийн засаглал, санхүү бүртгэл, татвар, аудит, байгаль орчин, чанарын удирдлагын тогтолцоо, хөрөнгө	Салбаруудын олон сургалтууд зохион байгуулагдсан.	ОНТ, төсөл хөтөлбөр, ХХ		Хэрэгцээ шаардлагад үндэслэн үе шаттайгаар сургалтад хамруулна.	1,2,3,4 улирал	АЗДТГ, ХХААГ	ХХУГ, ТХ, СХХ, МХГ, ГХБХБГ, МСҮТөв, Мэргэжлийн холбоод, Төсөл хөтөлбөр

	орүүлалт, аюулгүй чиглэлээр үйлчилгээ, сургалт зохион байгуулах	хөдөлмөрийн ажиллагааны зөвлөх сургалт зохион байгуулах			2020 онд 3 удаагийн сургалт мэдээлэлд 51 аж ахуйн нэгжийн 72 ажилчдыг хамруулан зохион байгуулсан	6-аас доошгүй удаагийн сургалт мэдээлэл зохион байгуулж, 120-оос доошгүй ажилчны стандартын мэдлэгийг сайжруулна.	1,2,3,4 улирал	СХХ	СЗДТГ	
3.10	Бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр батлагдсан үндэсний стандартуудаар төрөлжсөн сургалт, мэдээллийг цахим болон танхимаар зохион байгуулах	УТ								
Зорилт-4. Орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэлтийг дэмжиж, хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.										
4.1	Инновацийн бүтээгдэхүүнийг сурталчилах, жижиг, дунд үйлдвэрт зориулсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах, шинэ техник технологи, нутагшуулахад дэмжлэг үзүүлэх	XX				Аж ахуйн нэгжүүд инноваци болон байгальд ээлтэй дөвшилтэт техник, технологи шинээр нэвтрүүлэх эхлэл тавьсан байна.	1,2,3,4 улирал	БШУГ, ХХААГ,	Мэргэжлийн холбоод Хувийн хэвшил ХХҮГ, СХХ, МХГ	
4.2	"Техник технологи инноваци нэвтрүүлэх төв"-ийн ТЭЗҮ-д нийцсэн үйлдвэрлэл байгуулах хувийн хэвшлийн санал санаачлагад дэмжлэг үзүүлэх	Төсөл, хөтөлбөр, ААН		Үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдсан тус бүсэд "Бүрэн луу" ХХК мал нядлах цэгийн дэд бүтцийг шийдвэрлэсэн.	"БҮТТ"-д мах боловсруулах, ноос боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагчид таатай нөхцөл бүрдсэн байна.	1,2,3,4 улирал	АЗДТГ	ХХААГ, ГХБХБГ, СЗДТГ		
4.3	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ,	ОНТ, төсөл хөтөлбөр, ААН		"Булган мах маркет" ХХК 2022 онд 270 тн мах экспортлож, дулааны аргаар мах боловсруулах цех ашиглалтад оруулсан.	500 тн мах экспортод гаргах зөвшөөрөл авсан.	1,2,3,4 улирал	МЭГ, ХХААГ,	ХХААХҮЯ, Хувийн хэвшил		
4.4	Аймгийн төв болон сум суурин газруудад амьд мал, амьтан, түүхий эдийн	ОНТ, төсөл хөтөлбөр, ААН		Зураг төсөв нь хийгдсэн	Эхний ээлжид нэн шаардлагатай сумдад бүсчлэн байгуулах, хувийн	1,2,3,4 улирал	СЗДТГ, ХХААГ	XX		

	хүнсний хангамжийг нэмэгдүүлэх.	борлуулалтын байгуулах	цэг			хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.		
4.5	Аймгийн төвийн хүн амын хүнсний хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэх ажлыг зохион байгуулах	ООНТ, Хувийн хэвшил	Жил бүр 10.0 тн хүртэл нөөцийн мах бэлтгэн нийлүүлж байсан.	Хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, хямд үнэтэй мах нийлүүлэх ажлыг зохион байгуулна.	2023	АЗДТГ, ХХААГ	Булган сумын ЗДТГ, Хувийн хэвшил	
4.6	Орон нутаг сүүний үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх	УТ, 2.6 тэрбум	Аймгийн төвд "Хатан мээж хайрхан" ХХК хоногт 15-20 тн сүү боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулж, Шинэ хөдөө төслөөс 5 суманд олгосон сүү хөргөлтийн цэгээр дамжуулан жилд 400 тн сүү цуглуулж, боловсруулж байна.	Тэшиг суманд Сүү боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	2,3,4 улирал	ХХААГ	ХХААХҮЯ, Тэшиг сумын ЗДТГ,	
4.7	"Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлэх	УТ	Засгийн газраас сүүний урамшууллын журам батлагдсан.	Журамд заасны дагуу урамшуулал олгох арга хэмжээг зохион байгуулна.	1,2,3,4 улирал	ХХААГ	СЗДТГ, малчид фермер	
4.8	Булган сумын бетон зуурмагийн үйлдвэрийн тогтвортой үйл ажиллагааг хангах чиглэлийг аж ахуйн нэгжид өгөх	ААН	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Бетон зуурмагийн үйлдвэр байгуулагдсан	Орон нутгийн бүтээн байгуулалтад бетон зуурмаг нийлүүлж, хувь нэмэр оруулсан байна.	2,3 улирал	ХХ, ГХБХБГ	ХХААГ, БОАЖГ, хувийн хэвшил	
4.9	Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжих	ААН, УТ	Аймгийн хэмжээнд үйлдвэр байхгүй.	Хувийн хэвшлийн санал санаачлага ирсэн байна.	1,2,3,4 улирал	ХХААГ	БОАЖГ, СЗДТГ	

4.10	Шинэ хөдөө төслөөс олгогдсон тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, иргэдийн хөдөлмөрөөрөө хоршиход дэмжлэг үзүүлэх	УТ	"Шинэ хөдөө төсөл"-өөс 2017-2020 ондуудад 1 172 450 төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.	-	1,2,3,4 улирал	Шинэ хөдөө хөгжил ОНӨААТ УГ	СЗДТГ, ХХААГ
4.11	Хувийн хэвшлийн бүтээн байгуулагдаж байгаа зочид буудал, зам дагуух үйлчилгээний газруудад мэргэжлийн байгууллагууд зөвлөгөө арга зүйгээр дэмжлэг үзүүлэх	ОНТ	Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж байгаа зарим бүтээн байгуулалт батлагдсан зураг төсөвгүй байна.	Барилгын норм нормативын дагуу бүтээн байгуулалт хийгдэж, холбогдох стандартад нийцсэн тохижилт хийгдсэн байна.	2,3,4 улирал	ГХБХБГ, СХХ	Хувийн хэвшил
4.12	Ахуйн үйлчилгээний хөгжүүлж, салбарыг иргэдийн тогтвортой чанартай үйлчилгээ авах нөхцөл бүрдүүлэх	ОНТ-200.0 сая, төсөл хөтөлбөр	9 сум ахуйн үйлчилгээний төвтэй. Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний төвийн засварт орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Булган суманд АУТ барих газрыг шийдвэрлэсэн.	Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний төв ашиглалтад орсон байна. Сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	1,2,3,4 улирал	СЗДТГ, ХХААГ	хувийн хэвшил
4.13	Оёдлын үйлдвэрийн байрны гүйцэтгүүлж, захирал хувцас хөгжүүлэх	ХААХИ ОНӨУГ	16 суманд 42 цэгт 57 оёдолчин ажиллаж байна. (2-3 оёдлын машинтай цехүүд байна)	Оёдлын үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрч орон нутгийн хэрэгцээний биеийн тамир, ажлын болон оффис, захиалгат хувцас үйлдвэрлэж зах үзэлд нийлүүлсэн байна.	2,3,4 улирал	ХХААГ, Оёдлын үйлдвэр, "ХААХИ" ОНӨУГ	Үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний нэгдсэн холбоо
4.14	Ахуйн үйлчилгээ хоршооны салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	180 XX	Аймгийн хэмжээнд 12 суманд халуун усны үйлчилгээ үзүүлж байна.	Могод, Баян-Агт сумын халуун усыг ашиглалтад оруулж,	2,3,4 улирал	ГХБХБГ	СЗДТГ, ХХААГ

						Бүрэгхангай суманд хувийн хэвшлийн хөрөнгөөр халуун ус барих ажлыг гүйцэтгэнэ.				
4.15	Халуун ус, үс засах, хумс засах үйлчилгээг тохирлын баталгаанд хамруулах	ОНТ, ХХ	2020 онд 1 цэг тохирлын баталгаанд хамрагдсан	2020 онд 1 цэг тохирлын баталгаанд хамрагдсан	10 цэгийг тохирлын баталгаанд хамруулж, үйлчилгээний орчинг сайжруулна.	1,2,3,4 улирал	СХХ	Хувийн хэвшил		
4.16	Хоршооны салбарын мэдээллийн санг тогтмол баяжуулах	-	Аймгийн хэмжээнд 134 хоршоо бүртгэлтэй байгаагаас 43 хоршоо идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.			1,2,3,4 улирал	ХХААГ	ХААХХ, СЗДТГ		
4.17	Хоршоодын үйл ажиллагааг идэвхижүүлж, чадавхижуулах, туршлага солилцуулах	ОНТ, төсөл хөтөлбөр	Хоршоодын хөгжлийн үнэлгээ хийгдсэн. GIZ- Эдийн засгийн өсөлт ба бизнес эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн шийдэл ТББ- тай хамтран чадавхижуулах сургалтад хамруулсан.		GIZ- Эдийн засгийн өсөлт ба бизнес эрхлэлтийг дэмжих төслөөс хоршоодыг чадавхижуулах үе шаттай сургалтад хамруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	1,2,3,4 улирал	ХХААГ, GIZ	ХААХХ, СЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ		
4.18	Түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	Төсөл хөтөлбөр	Шинэ хөдөө Булган төслийн хүрээнд 15 суманд түүхий эд боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлсэн.		Боловсруулсан арьс нэхийг оёдлын үйлдвэрээр дамжуулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлсэн байна.	2,3,4 улирал	ХХААГ, Шинэ хөдөө төсөл, Оёдлын үйлдвэр	ХХУГ, СЗДТГ		
Зорилт-5. Жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийг өргөтгөх, борлуулалтад дэмжлэг үзүүлэх;										
5.1	Жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийг өргөтгөх,	Төрийн худалдан авах үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ	ОН, ААН, иргэд	Төрийн байгууллагууд 2022 онд дотоодын зах зээлээс 1.7 тэрбум	Аймгийн Засаг даргын 2021 оны А/22 тоот Захирамжийн	1,2,3,4 улирал	Статистикийн хэлтэс	СЗДТГ, ХХААГ, Төр, төсвийн байгууллага,		

	борлуулалтад дэмжлэг үзүүлэх	эрхлэлтийг худалдан авалтаар бизнесийн бүрдүүлэх таатай орчныг бүрдүүлэх	худалдан авалт дэмжиж, орчныг бүрдүүлэх	төгрөгийн худалдан авалт хийсэн	хэрэгжилт хангагдаж, дотоодын худалдан авалт өмнөх оноос нэмэгдсэн байна.	хувийн хэвшил		
5.2	Уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулалтаар дэмжих /Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, ЖДҮ-ийг дэмжих зохицуулалтыг хэрэгжүүлэх/	Уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулалтаар дэмжих /Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, ЖДҮ-ийг дэмжих зохицуулалтыг хэрэгжүүлэх/	Уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулалтаар дэмжих /Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, ЖДҮ-ийг дэмжих зохицуулалтыг хэрэгжүүлэх/	ААН	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т аймгийн ЖДҮЭ-ийн судалгаа, хамтран ажиллах санал хүргүүлсэн.	3Г-ын 2019 оны 224-р тогтоолд тусгагдсан Булган, Сэлэнгэ, Төв аймагт уул уурхай, ХХАА-н аж үйлдвэрийн цогцолборуудыг байгуулах зорилтын хэрэгжилтийг хангана.	АЗДТГ, ХХААГ 1,2,3,4 улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, бусад томоохон уул уурхайн ААН
5.3	Дижитал суурилсан контент бэлтгэж, орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан таниулах, цахим худалдааг хөгжүүлэх, маркетинг болон сурталчилгаа хийх үр чадварыг хөгжүүлэхэд анхаараж ажиллах	Дижитал суурилсан контент бэлтгэж, орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан таниулах, цахим худалдааг хөгжүүлэх, маркетинг болон сурталчилгаа хийх үр чадварыг хөгжүүлэхэд анхаараж ажиллах	ОНТ, хувийн хэвшил, төсөл хөтөлбөр	Маркетинг, брендинг, борлуулалт сургалт зохион байгуулсан	Булганы үйлдвэрлэл эрхлэгчдийн цахим худалдааны платформ үүсгэж, борлуулалтад нь дэмжлэг үзүүлнэ.	ХАҮТ, БОАЖГ, хувийн хэвшил		
5.4	"Булганд үйлдвэрлэл" худалдааны төвлөрсөн цэг байгуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлэх	"Булганд үйлдвэрлэл" худалдааны төвлөрсөн цэг байгуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлэх	ОНТ, хувийн хэвшил	ХХҮГ-аас 1 өрөөг түрээслэн ажиллуулж байна.	Томоохон худалдааны төв цэгүүдэд "Булганд үйлдвэрлэл" цэг байгуулна.	СЗДТГ		
5.5	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчилан үзэсгэлэн яармагийг зохион байгуулж, ОУ болон бүс нутгийн үзэсгэлэн	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчилан таниулах үзэсгэлэн яармагийг зохион байгуулж, ОУ болон бүс нутгийн үзэсгэлэн	ОНТ, хувийн хэвшил /10.0/	2018 онд цагаан сар үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Цагаан сар, Намрын ногоон өдрүүд, "Airag day" зэрэг үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна.	Орон нутгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, гадаад дотоодын бизнес арга хэмжээнд хувийн хэвшлийг	ХХҮГ, ХАҮТ, СЗДТГ, хувийн хэвшил		

		худалдаанд эрхлэгчдийг байгуулж оролцуулах	Хөвсгөл, Орхон, Дархан-Уул аймгуудтай бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлж, ХАА-н гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгох	ОНТ, төсөл хөтөлбөр, ААН	Хутаг-Өндөр сум Хөвсгөл аймагтай, Сэлэнгэ, Хангал, Бугат, Орхон, Сайхан зэрэг сум Орхон, Дархан-Уул аймагт ХАА-ын гаралтай бүтээгдэхүүн нийлүүлж байна.	зохион байгуулж, оролцуулж, орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг сурталчилсан байна.	Бизнесийн туршлага судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэх санамж бичиг үйлдэж, хэрэгжүүлнэ.	XXAAГ 2,3,4 улирал	СЗДТГ, хувийн хэвшил, Мэргэжлийн холбоод
5.6									
Зорилт-6. Аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө:									
6.1	Аялал жуулчлалын хялбаршуулсан стандарт	Зочлох үйлчилгээ, ариун цэврийн стандартын сургалт зохион байгуулах	ОНТ	16 сум, 1 тосгонд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд зөвлөн туслах ажил явуулсан.	Аялал жуулчлалын салбар хүний нөөц чадавхжиж, менежмент сайжирна.	II улирал	БОАЖГ	СХЗХ	
6.2	Аялал жуулчлалын төрөлжсөн сургалт зохион байгуулах (Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт, Могод, Рашаант)	Сумдын "Айлчин" гэрээр сонгогдсон цэгүүдэд сургалт зохион байгуулах	ОНТ	Стандарт хэмжил зүйн хэлтэс аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах сонирхолтой аж ахуйн нэгж, иргэдэд айлчин гэр ажиллуулах журмын танилцуулгыг цахимгаар хийсэн.		05.01-08.10	БОАЖГ, СХЗХ	СЗДТГ	
6.3	Байгальд ээлтэй аялал жуулчлал	Булганаар аялах 3 дүрэм, ул мөргүй аялах 3 зарчим зөвлөмж боловсруулах	-	-	Аялагчдын аяллын боловсролыг дээшлүүлэх, тогтмолжуулж хэвшүүлэх	05.01	ААЖХ	БОАЖГ, СЗДТГ	
6.4		"Булган аймгийн өвлийн спортын наадам"-ын арга хэмжээг зохион байгуулах	ОНТ, ААНБ	Хангал сумын Хялганат тосгонд зохион байгуулсан.	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх эхлэл болно.	12 сар	АЗДТГ	ААЖХ БТСГ Мэргэжлийн холбоод	
6.5	"Булганы бөгц" брэнд бүтээгдэхүүнийг гаргах	Аймгийн нэрийн бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг тодорхойлох, дизайны гаргах	ОНТ, ААНБ	-	Аялагч жуулчдад зориулсан аймгийн нэрийн брэнд бүтээгдэхүүний	07.01	ААЖХ	XXAAГ, Шинэ хөдөө төсөл	

6.6	Хангинахын шугуйн шагайн тойром	Хугаг-Өндөр суманд зохион байгуулах	ОНТ 5,000.0	Хангинахын шугуйн шагайн тойрмыг Хугаг-Өндөр суманд 2022 оны 05 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан.	Соёлын биет бус өвийг сурталчлан таниулна.	05.21-22	СУГ	БТСГ, Шагайн холбоо, Үндэсний өвийн газар, СУИС
6.7	"Airag Festival" арга хэмжээг зохион байгуулах	Орхон, Сайхан сумын зааг Өрмийн нуурын дэргэд зохион байгуулж, бүх сумд хамрагдах	ОНТ 50,000.0	"Айраг наадам" арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдөр зохион байгуулсан.	Айраг, адууны соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчлан жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	08.12-14	АЗДТГ, ААЖХ	БОАЖГ
6.8	"Airagday" үзэсгэлэн худалдаа, өдөрлөг зохион байгуулах	Улаанбаатар хотод зохион байгуулна	ОНТ 20,000.0	2022 оны 10 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан.	Орон нутгаа сурталчилж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.	10.07-08	АЗДТГ, ААЖЗ ААЖХ	БОАЖГ
6.9	Олон улсын аялал жуулчлалын ITM үзэсгэлэнд оролцох	16 сум 1 тосгон, 30-аас доошгүй ААНБ-ыг хамруулах	ОНТ	2022 оны 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд "ITM-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаанд түнш аймгаар оролцсон.	Айраг орон нутгаа сурталчилж, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, сайжирна.	10.28-29	ААЖХ	БОАЖГ, СЗДТГ
6.10	Буриад өв соёл, урлаг, спортын "Их Алтаргана-2024" олон улсын их наадамд оролцох	Наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайн хийж, чанартай сайн зохион байгуулах	ОНТ, ААНБ	"Их Алтаргана-2022" наадамд 2022 онд ОХУ-ын Чита хотод явж оролцсон.	Буриад ястны өв соёлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, Оросын холбооны улсын Буриад улстай хамтран ажиллах үйл ажиллагаа идэвхжинэ.	3 дугаар улирал	ААЖХ	СУГ, ААНБ, нутгийн иргэд, мэргэжлийн байгууллага, ТББ
6.11	Улсын хэмжээнд Булган аймгийн эко аялал жуулчлалыг сурталчлах	Уламжлалт болон цахим орчинд эвент арга хэмжээг сурталчлах	Үйл ажиллаг аагаар	Аялал жуулчлалын Visitbulgan.mn вэб сайтыг хийсэн.	Булган аймгаар аялах үндсэн болон дэд маршрутудыг тодорхой болгох	Жилийн турш	ААЖЗ	БОАЖГ, ААЖХ

6.12	Аялагч жуулчдад зориулсан тэмдэг тэмдэглэгээг хийх	Төв зам дагуух тэмдэг тэмдэглэгээ шинээр 5ш хийх /2x4м/, хөх	ОНТ	Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчилэн сумдад 5ш тэмдэглэгээ хийсэн.	Зорин ирсэн аялагчид төөрдөггүй, мэдээллээр хангагдах боломжтой болно. Санаандгүй аялагчдад санал болон харагдана	06.15	БОАЖГ	СЗДТГ
6.13	Аялал жуулчлалын форумыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ААНБ, сумдын удирдлагыг бүрэн хамруулах	ОНТ	"VisitBulgan-2022" аялал жуулчлалын форумыг 2022 оны 01 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх жилд хийгдэх ажлыг төр төсвийн байгууллагад танилцуулан санал бодлоо солилцож, нэгдсэн нэг зорилготой болсон байна.	01620	БОАЖГ	ААЖХ, ААЖХ, МАЖХ
6.14	Сумын Засаг дарга нартай жуулчлал, амралтын чиглэлээр олгогдсон цэгийн судалгааг гаргаж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох	Цаашид авах арга хэмжээг тодорхойлон төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх	ОНТ	-	Шилэн аймаг болох эхлэлийг тавина.	Жилдээ	СХЗХ	Сумын Засаг дарга нар БОАЖГ ГХБХБГ
6.15	Аялал жуулчлал хог дагасан хаягдлын асуудлыг шийдвэрлэх	Аялагч, жуулчид ихээр очиж төвлөрөл үүсгэн хог хаягдал ихээр үүсдэг газруудад хог хаягдлыг багасгах, ангилан ялгах ажлыг зохион байгуулах (Их булаг, Хануй, Цагаан гол, Хульж, Хунт, Цачирт, Элсэн тасархай)	ААНБ	-	Рашаан ус, орчны бохирдол доройтол багасна.	5-9 сар	БОАЖГ	СЗДТГ, ААЖХ
6.16	Хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авах	Амралт, рашаан сувилал, жуулчны баазын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд хөрсөнд нэвчилтгүй боловсон жорлон ашиглах	ААНБ	-	Хөрсний бохирдлыг бууруулж, аялагчдын тухтай байдлыг хангана.	06.01	ААЖХ	БОАЖГ

6.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх, хяналт шинжилгээ үнэлгээ

7.1	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 сарын 01-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, тайлагнаж, ХХААХҮЯ-д явуулна.	ОНТ	-	Хяналт, шинжилгээ хийх журмын дагуу гүйцэтгэнэ.	4 улирал	АЗДТГ, ХХААГ	Оролцогч талууд, СЗДТГ
7.2	Хяналт, шинжилгээ үнэлгээ		-	Хяналт, шинжилгээ хийх журмын дагуу гүйцэтгэнэ.		АЗДТГ, ХХААГ	СЗДТГ